



OPEN ACCESS

*CORRESPONDENCE

Myagmarsuren Dashzevge

E-mail address:

myagmarsurend@must.edu.mn

RECEIVED: November 2, 2023

ACCEPTED: December 20, 2023

PUBLISHED: December 29, 2023

CITATION

M. Dashzevge, "Geo-energy and Activities, Energy Policy of the Mongolia: Problems, Challenges, and Solutions", Journal of Energy Transition, vol. 1, no. 1, pp. 31–41, Dec. 2023.

<https://doi.org/10.59264/jet.v1i1.23>

COPYRIGHT

©2023 by the authors. Submitted for possible open access publication under the terms and conditions of the Creative Commons Attribution (CC BY) license.

Geo-energy and Activities, Energy Policy of the Mongolia: Problems, Challenges

Myagmarsuren Dashzevge*

¹(Mongolian University of Science and Technology, Ulaanbaatar, Mongolia)

Abstract - This article summarizes research reports on the foundations of geo-energy study theory, dynamic change and transition in international relations or geopolitical fields, geo-economics fragmentation, and the new distribution of powers in the region. Based on the situation analysis, I tried to explore the dangers and risks facing the national security of the country. Moreover, policy analysis was conducted on energy strategy policy that stated mid and long-term development concepts of the country. One can distinguish the Mongolian energy strategy into two objectives:

1. To establish and maintain energy security;
2. To keep and grow in the role of an energy-market player.

According to geo-energy theory, the Mongolian energy policy can be divided into three separate fields, such as 1) Steps according to the changes and risks associated with world order; 2) Steps according to the third-neighbor policy; and 3) Steps according to cooperation with two neighbors.

The dynamics of the change in the world energy sector have naturally dragged Mongolia into its competitive field as a country that has tremendous resources of clean energy and critical minerals. Although Mongolia has the potential to be a big player in the field, it has to play along with super players in the field and consider their interests and arrangements. To attract foreign investment and high technology, Mongolia should employ an attractive policy in the long term. It requires the country to be active in the world energy field and to calculate future energy trends, dynamics, and arrangements correctly.

Key words - Energy geopolitics, Security, Geoeconomic fragmentation, Energy strategy, Third neighbor policy, Energy actor.

Гео-эрчим хүч ба Монголын эрчим хүчний бодлого, үйл ажиллагаа: Асуудал, сорилт

Дашзэвгийн Мягмарсүрэн*

¹(Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Улаанбаатар, Монгол улс)

Хураангуй - Энэхүү өгүүлэлээр судлаачдын дэвшүүлсэн гео-эрчим хүч судлалын онолын үндэслэл болон олон улсын харилцаа, геополитикийн талбар дахь динамик өөрчлөлт, шилжилт, гео-эдийн засгийн хуваагдал, бүс нутаг дахь хүчний шинэ хуваарилалтын талаар судалгааны тайлангуудыг тоймлон судлав. Дээрх онол арга зүй, тойм судалгаанд үндэслэн Монгол Улсын аюулгүй байдал, гадаад бодлогын үзэл баримтлалд тулгарч буй эрсдэл, сорилт бэрхшээлд нөхцөл байдлын шинжилгээ хийсний зэрэгцээ Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн үзэл баримтлал, баримт бичигт тусгагдсан эрчим хүчний стратегид бодлогын дүн шинжилгээ хийв. Монгол Улсын эрчим хүчний стратегийг хоёр зорилгод хувааж болно. Үүнд:

1. Эрчим хүчний аюулгүй байдлыг хангах, бэхжүүлэх,
2. Эрчим хүчний тоглогчийн байр сууриа хадгалах, өргөжүүлэх гэсэн хоёр зорилгод хувааж болно.

Мөн гео-эрчим хүчний үүднээс Монголын эрчим хүчний тоглолтын загварыг 1) дэлхийн дэг журамд гарч буй шилжилт, эрсдэлийг тооцон хийх алхам, 2) гуравдагч хөршийн үзэл баримтлалыг хүрээнд хийгдэх алхам, 3) хоёр хөрштэй харилцах, хамтран ажиллах арга барил хэмээн гурван талбарт хувааж үзлээ.

Дэлхий дахиныг хамарсан эрчим хүчний шилжилт нь цэвэр эрчим хүч, өндөр технологийн түүхий эдийн арвин нөөцтэй монгол орныг эрчим хүчний геополитикийн өрсөлдөөнд аяндаа татан оруулав. Эрчим хүчний нөөц нь монголыг эрчим хүчний тоглогчийн жин нөлөөг өсгөх хэдий ч эрчим хүчний супер тоглогчдын эрх ашиг, нөлөөлөл, тохиролцооноос ангид, дан монголын сонирхол, тоглолтоор үр дүнд хүрэх ямар ч боломжгүй юм. Тэрчлэн гадаадын хөрөнгө оруулалт татах, технологи нэвтрүүлэхийн тулд бодлого, эрх зүйн тогтвортой бөгөөд таатай орчныг бүрдүүлэх, дэлхийн ирээдүйн чиг хандлага, өрнөл, тохироог урьдчилан тооцож, өөрийн идэвх санаачилгаа алдахгүй, эрх ашгийн уялдааг хангаж хөдлөх нь дотоод идэвх санаачилгаас бүрэн шалтгаална.

Түлхүүр үг: Эрчим хүчний геополитик, Аюулгүй байдал, Гео-эдийн засгийн хуваагдал, Монголын эрчим хүчний стратеги, Гуравдагч хөршийн бодлого, Эрчим хүчний тоглогч.

I. ОРШИЛ

Геополитик, стратегийн салбарын шинэ тутам судалгаанд цаг уурын өөрчлөлт, эрчим хүч, нөөц баялгийн улс төр, дүрвэгсдийн асуудал, хосолмол дайн зэрэг өөр хоорондоо харилцан хамааралтай бөгөөд дэлхийн улс төрийн хэлэлцүүлэг, яриа мэтгэлцээний төдийгүй олон улсын тоглоомын дүрмийг шийдвэрлэхүйц олон сэдэв эрчимтэй хэлэлцэгдэж байна.

Сүүлийн жилүүдэд өрнөж буй олон улсын үйл явдал, чиг хандлагаас шалтгаалан геополитик, стратегийн судлагдахуун улам бүр нарийвчлагдаж, гео-улс төр (geopolitics), гео-эдийн засаг (geo-economics), геостратеги (geostrategy) хэмээх уламжлалт ухагдахуунуудаас хэдийн хальж гео-эрчим хүч (geo-energy), гео-аюулгүй байдал (geo-security), геотехнологи (geo-technology), гео-соёл (geo-culture), гео-философи (geophilosophy) зэрэг газарзүйд суурилсан салбар дундын судалгаа идэвхтэй хөгжих болов. Ялангуяа улс гүрнүүдийн эрчим хүчний төлөөх өрсөлдөөн, зөрчилдөөнөөс шалтгаалан гео-эрчим хүчтэй холбоотой эрдэм шинжилгээний бүтээл, өгүүлэл сүүлийн жилүүдэд цөөнгүй хэвлэгдэж байна.

Монгол Улс нь нэг талаас эрчим хүчний нөөц бололцоогоор бүс нутагт төдийгүй эрчим хүчний супер тоглогчдын сонирхлыг татах, улмаар хамтран ажиллах, хөрөнгө оруулалт хийж буй зэрэг нөхцөлөөс үүдэн эрчим хүчний дипломат бодлогыг эрчимжүүлэх, нөгөө талаар эрчим хүчний тоглолтоор дамжуулан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын бодлого, улс төр, эдийн засгийн эрх ашгаа хангах, хамгаалах, олон улсын хамтын ажиллагаан дахь байр сууриа хадгалах, бэхжүүлэх бололцоо бүрдэж байна. Тэрчлэн дэлхий дахины геополитик, аюулгүй байдлын чиг хандлага, хөрш орнуудын эрчим хүчний стратеги, үйл ажиллагааны өрнөлийг харгалзан эрчим хүчний аюулгүй байдлын үзэл баримтлал, хэрэгжүүлсэн бодлого үйл ажиллагааг эргэн харах, шинээр томъёолох шаардлага бүрэлдсэн гэж үзэж байна.

Сэдвийн хүрээнд судалгаа шинжилгээний шинэ тутам үзэл баримтлал, тойм, дүн шинжилгээнд тулгуурлан Монгол Улсын эрчим хүчний геополитикийн төлөв байдлыг таамаглах, бодлогын үр нөлөөг үнэлж цэгнэх хэрэгцээ шаардлага тулгарч байна. Энэ зорилтын хүрээнд тус өгүүлэлд гео-эрчим хүчний онолын судалгааны тойм, чиг хандлагыг авч үзэхийн зэрэгцээ Монголын эрчим хүчний улс төр, аюулгүй байдлын бодлого, үйл ажиллагааны талаар судлаачийн байр суурь, саналаа дэвшүүлэхийг хичээв.

II. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэхүү өгүүлэлд эрчим хүчний аюулгүй байдал, геополитикийн талаар олон улсын хэмжээнд бичигдсэн эрдэмтэн судлаачдын зохион бүтээлд хийсэн тойм

судалгаа болон эпистемологи хандлагаар эрчим хүчний геополитикийн үзэл санааны хөгжил, өрнөлд хийсэн дүгнэлт, тайлбарыг нэгтгэн тоймлов. Тэрчлэн олон улсын харилцаа, гео-эдийн засгийн орчинд гарч буй динамик өөрчлөлт, шилжилтийн талаар олон улсын судалгааны байгууллагуудын хийсэн тайлан дүгнэлт, зөвлөмж, олон улсын түвшинд гарч буй үйл явдал, өрнөлд хийсэн ажиглалт, нөхцөл байдлын шинжилгээнд үндэслэн Монгол Улсын эрчим хүчний аюулгүй байдал, геополитикт учирч болзошгүй эрсдэл, сорилт бэрхшээлийг тодорхойлохыг зорив.

Монгол Улсын эрчим хүчний чиглэлээрх дунд болон урт хугацааны стратеги, үзэл баримтлалд дүн шинжилгээ хийж, бодлогын үндсэн зорилтыг 1) эрчим хүчний аюулгүй байдлыг хангах, бэхжүүлэх, 2) эрчим хүчний тоглогчийн байр сууриа хадгалах, өргөжүүлэх гэсэн хоёр үндсэн хэсэгт хуваан, хэрэгжүүлж буй алхмуудад нөхцөл байдлын болон бодлогын шинжилгээ хийж, үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын зорилтоо хангахын тулд гео-эрчим хүчний ямар тоглолт, арга барилыг баримтлан хэрэгжүүлэх тухай судлаачийн санал, хувилбарыг дэвшүүлэв.

III. ҮР ДҮН БА ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

A. Гео-эрчим хүч нь геополитикийн хавсрага чиглэл болох нь

Эрчим хүчний аюулгүй байдал хэмээх ойлголт 1947 онд АНУ үндэсний аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд хууль тогтоомжид анх тусгагджээ. Харин 1979 онд Америкийн судлаач Мелвин А.Конант “Эрчим хүчний геополитик” (Energy geopolitics) сэтгүүлийг гаргаж эхэлсэн цагаас судалгааны эргэлтэд эрчимтэй орж эхэлсэн. Улмаар Бренда Шаффер [1], Стив Вандерхайден [2], Даниел Ергин [3] нар эрчим хүчний улс төрийн чиглэлээр, эрчим хүчний геополитик, бодлого судлалын асуудлаар Ж.Митчелл, П.Бэк [4], Майкл С.Хамилтон [5], Майкл Клэр [6], Гавин Бриж [7] нарын дагнасан томоохон бүтээлүүдээс гадна дэлхийн бодлого, олон улсын харилцаанд эрчим хүчний эзлэх байр суурь, үзүүлэх нөлөөллийн талаар америкийн судлаач З.Бжезинский [8], болон Европын судлаачид болох Г.Чуфрин [9], Б.Гокай [10] нар судалгаандаа авч үзсэн байдаг. Хувь судлаач, шинжээчдээс гадна Олон улсын эрчим хүчний агентлаг, Олон улсын цөмийн болон сэргээгдэх эрчим хүчний агентлаг, Дэлхийн эрчим хүчний зөвлөл зэрэг дэлхийн эрчим хүчний харилцааг зохицуулах, зөвлөмж боловсруулах, хяналт тавих зорилго бүхий байгууллагуудын зэрэгцээ улс орны эрчим хүчний стратеги, бодлогын судалгаагаар дагнасан Оросын эрчим хүчний стратегийн хүрээлэн, Өмнөд Солонгосын эрчим хүчний судалгааны хүрээлэн, Японы тогтвортой эрчим хүчний бодлогын хүрээлэн, Хятадын эрчим хүчний судалгааны хүрээлэн, Шинэ эрчим хүчний судалгааны хүрээлэн зэрэг эрчим хүчний асуудлыг дагнан судалдаг

бүс нутаг дахь улс орны судалгааны төв хүрээлэнгүүд идэвхтэй ажиллаж байна.

Харин эрчим хүчний геополитикийн талаар олон ойлголт, тодорхойлолт байдаг хэдий ч АНУ-ын төрийн нарийн бичиг асан Хенри Киссинжерийн 1970-аад онд тавьсан нэгэн илтгэлд “Хэн газрын тосыг хяналтандаа авна, тэр улс үндэстнүүдийг хянах болно. Хэн хоол хүнсийг хянаж чадна, тэр хүн ардыг хянаж чадна” хэмээсэн нь эрчим хүчний геополитикийн утга агуулгыг энгийн бөгөөд ил шулуун илэрхийлсэн гэж хэлж болно.

Эрчим хүчний геополитикийг улам нарийвчлан гео-эрчим хүч хэмээх нэр томъёогоор илэрхийлэх санааг 2015 онд Грекийн судлаач И.Видакис, Ж.Балтос нар дэвшүүлжээ.

Хүснэгт 1. Геополитикийг шинэ утга, нэр томъёогоор илэрхийлснийг харуулсан жагсаалт

Нэр томъёо	Тухайн нэр томъёог ашигласан судалгааны ажлын жишээ
Геополитик	А.Чандра [11], С.Митяков, бусад [12], [13]
Газрын тосны геополитик (Geopolitics of Oil)	К. Арванитополос [14], П.Бастело [15], Л.Патий, [16]
Хуучин геополитик (Old Geopolitics)	А.Гупта, С. Арора [17]
Шинэ геополитик (New Geopolitics)	Ф. Жэрэ [18], К.Паскуал [19]
Шинэ эрчим хүчний геополитик (New Energy Geopolitics)	Б.Коскун, Р.Карлсон [20]
Эрчим хүчний геополитик (Energieopolitics)	Д.Арибоган, М.Билгин [21]
Эрчим хүчний газар зүй (Geography of energy)	Д. Соломон, Э.Калверт [22]
Гео-эрчим хүч (geoenergy)	А.Манэ-Эстрада [23], И.Видакис, Ж.Балтос [24]


Тэдний үзэж буйгаар гео-эрчим хүч гэдэг нь улс төр, эдийн засгийн тогтолцоонд төдийгүй олон улсын харилцаанд эрчим хүчний нөөцийн үзүүлэх нөлөөллийг авч үзэхэд орших аж. Тэрчлэн улс үндэсний болон олон улсын талбар дахь улс төрийн шийдвэр гаргах үйл явцад хоёр үе шаттай дүн шинжилгээ хийдэг байна. Үүнд:

1. Эрчим хүчний нөөцийн талаар мэдээлэлд боловсруулалт хийх замаар газарзүйн нөхцөл шалтгаанаас үүдэлтэй улс төр, эдийн засаг цаашлаад нийгмийн салбар дахь шийдвэр гаргах үйл явцыг судлах.
2. Эрчим хүчний бэлэн нөөц хийгээд тухайн нөөцийг ашиглах боломж чадавх болон улс төрийн шийдвэр, үйл ажиллагааны хоорондын харилцан хамаарлыг авч үзэх үе шатнаас бүрдэнэ.

Дэлхийн болон бүс нутгийн түвшний эрчим хүчний харилцан хамаарлын судалгаа нь 1) шинэ технологи нь эрчим хүчний нөөцийн хомсдолын асуудлыг

шийдвэрлэхэд хэрхэн нөлөөлж буй хийгээд томоохон бүс нутгуудын геостратегийн учир холбогдлыг хэрхэн өөрчилж буйг ажиглан шинжлэх буюу эрчим хүчний салбар дахь шинэ технологийн нөлөөллийг үнэлж дүгнэх, 2) эрчим хүчний нөөцийн хомсдол ба улс төрийн тодорхой шийдвэрийн шалтгаант хамаарлыг тооцож, эрчим хүчний дутагдлын талаар тоон болон чанарын өгөгдлийг цуглуулах, 3) дэлхийн улс орнуудыг тэдгээрийн хяналтад буй эрчим хүчний нөөц баялгаар нь ангилан хувааж, улмаар холбогдох улс төрийн шийдвэр дэх эрчим хүчний аюулгүй байдлын аспектэд хяналт шинжилгээ хийхэд чиглэх аж. [24]

Судлаачдын авч үзсэнээр гео-эрчим хүч нь газар зүй, геополитик, гео-эдийн засаг, гео-соёлын адил дэлхий дахины геостратегийн “дагуул” сэдвийн нэг бөгөөд улс төрийн шийдвэр гаргалтын түлхүүр хүчин зүйл болох эрчим хүчийг судалдагараа онцлог юм. Эрчим хүч нь дэлхий дахины хүчний хуваарилалтад тэргүүлэх үүрэг рольтой бөгөөд улс төр, эдийн засгийн хүчтэй харилцан нөлөөлж, улмаар давамгайллын гурвалсан харилцаа үүсгэдгийг доорх зургаар илэрхийлжээ.



Зураг 1. Давамгайллын гурвалжин буюу харилцан хамааралт хүчнүүдийн загвар. Эх сурвалж: [25]


Бразилийн судлаач Л.Оливьер хөгжиж буй улс орнуудын эрчим хүчний геополитикт хийсэн шинжилгээндээ эрчим хүчний нөөц баялгийг хянах, технологи эзэмших, эрчим хүчний дэд бүтэц, тээвэрлэлт болон эрчим хүчний нөөц ашиглалтад нөлөөлөх геополитикийн болон стратегийн бүхий л бүрдэл элементийн цогцыг эрчим хүчний геополитик гэж нэрлэж болно хэмээжээ. Оливьерын дэвшүүлсэн үзэл баримтлалын үүднээс эрчим хүчний геополитикийн судалгааны хувьсагч нь 1) эрчим хүчний үндсэн нөөцийн газар зүйн байршил, хуваарилалт болон эрчим хүчний нөөцийн төрлүүд, 2) эрчим хүчний экспортлогч, импортлогч орнууд болон томоохон үйлдвэрлэгч, хэрэглэгч төвүүдийн газар зүйн байршил, 3) экспортлогч болон импортлогч орнууд болон эрчим хүчний томоохон хэрэглэгч тоглогчдын геополитик, стратегийн маргаан, 4) эрчим хүчний салбар дахь бусад улс орны нөлөөлөл болон эрчим хүчний аюулгүй байдлаа хангахад чиглэсэн улс гүрнүүд, олон улсын эвслийн стратеги тус тус тооцогдох аж. [26]

Эрчим хүчний геополитик нь шинэ зуунд бүрэлдэн хөгжсөн салбар хэдий ч геополитикийн ухаан анх үүссэн XX зууны эхээр эрчим хүчний асуудлыг тус салбарын судалгаанд тооцож үзэхийг тухайн үеийн эрдэмтэн судлаачид санал болгосон нь цөөнгүй. Тухайлбал, геополитикийн сонгодог онолын төлөөлөгч бөгөөд Английн газарзүйч, олон улсын харилцааны онолч Х.Маккиндер 1904 оны 01 сарын 25-нд Хатан хааны газарзүйн нийгэмлэгт уншсан “Түүхийн газар зүйн тэнхлэг” хэмээх алдарт илтгэлдээ эрчим хүчний асуудлаарх хоёр нөхцөл байдалд анхаарал хандуулахыг зөвлөсөн байдаг. Нэн тэргүүнд английн нүүрсийг далайгаар, германы нүүрсийг газраар тээвэрлэхэд үүсэж буй өрсөлдөөний нөхцөлийг хөндсөн байна. Мөн Монгол болон Оросын эзэнт гүрний өргөн уудам орон зай дахь хүн ам, хөвөн даавуу, түлш эрчим хүч, төмрийн хүдэр бүхий аугаа том эдийн засгийн талбарыг холбосон дэд бүтэц ялангуяа төмөр замын сүлжээнд анхаарал хандуулах шаардлагатайг танилцуулсан байдаг [27]. Евро-азийн өргөн уудам талбарт улс орнуудыг дамнан дэд бүтцийн сүлжээг байгуулах, өргөжүүлэх, хянахын төлөө их гүрнүүдийн өрсөлдөөн хийгээд хамтын ажиллагаа өдгөө ч үргэлжилсээр байгаа нь Х.Маккиндерийн хоёр жарны тэртээ хийсэн дүгнэлт өдгөө ч учир холбогдлоо алдаагүйг илтгэнэ.

В. Дэлхийн шеополитикийн нөхцөл байдал ба Монголын эрчим хүчний бодлого

Гео-эрчим хүчний талаар дээр дурдсан тодорхойлолтын үүднээс Монгол Улсын гадаад бодлого, аюулгүй байдлын үзэл баримтлалд тулгарч буй сорилт бэрхшээл, гадаад, дотоод хүчин зүйл хийгээд Монгол улсын засгийн газраас эрчим хүчний стратегиа хэрэгжүүлэхээр эрмэлзэж буй улс төр, эдийн засгийн урт хугацааны бодлого шийдвэр, үйл ажиллагааны бодит алхмуудад тодорхой дүн шинжилгээ хийж болно.


2008 оны дэлхийн санхүүгийн хямралын дараагаас эдийн засгийн интеграци саарч, худалдааны шинэчлэл, нээлттэй худалдааг өргөжүүлэх улс төрийн дэмжлэг сулран улмаар даяаршил саармагжиж буйг судлаачид “удаашрал” (slowbalization) хэмээн нэрийдэх болов [28]. Тэрчлэн АНУ, Хятадын худалдааны дайн, Covid-19 цар тахал, 2022 онд эхэлсэн Орос-Украины дайны уршгаар дэлхий дахинд гео-эдийн засгийн хуваагдал (geoeconomic fragmentation) эрчимтэй явагдаж буйг судалгааны үр дүнгүүд ч илтгэж байна.



Зураг 2. Геополитикийн хурдцмал байдлын өсөлт ба гадаадын шууд хөрөнгө оруулалтын хуваагдал. Эх сурвалж: Олон талт харилцааны ирээдүй ба гео-эдийн засгийн хуваагдал. ОУВС. 2023/002 [29]

Дэлхийн гео-эдийн засгийн хуваагдал нь ганц туйлт дэг журмаас олон туйлт руу, глобал харилцаанаас бүс нутгийн шинжтэй, нийцэл зохицлоос туйлшрал руу хөтөлж буй тул геополитикийн “шинэ хэвшил (new normal)” [30], геополитикийн дараагийн эрин [31]-д улс орнууд аюулгүй байдлын асуудлаасаа хальж “тэсэж үлдэх стратеги” [32] баримтлахад хүрч байна. Энэхүү эрсдэл нь эрчим хүчний салбарыг ч тойрсонгүй. Ялангуяа Орос-Украины дайны улмаас эрчим хүчний түүхий эдийн үнийн өсөлт, эрчим хүчний хомсдолоос шалтгаалсан эрчим хүчний дайны төлөв нь улс орнууд эрчим хүчний хүчний аюулгүй байдлын үзэл баримтлал, стратегиа эргэн харахад хүргэж, эрчим хүчний тогтолцоо, нийлүүлэлтийн сүлжээ, технологи, түүхий эдийн нөөц хувилбар, хөрөнгө оруулалтын болон зохицуулалтын бодлогоо цогцоор нь шинэчлэх, шилжилт хийхийг эрмэлзэх болов. Уг асуудлыг бүхэлд нь “эрчим хүчний шилжилтийн геополитик” хэмээх ойлголтын хүрээнд судлан авч үзэж байна [33].

Дэлхий дахин худалдаа, гео-эдийн засгийн лагерьд хуваагдахад хүрвэл бүс нутагт хамгийн их хохирох орны тоонд судлаачид Монгол улсыг онцолж байна [34].



Зураг 3. Эрс хуваагдлын үеийн сценари дахь хохирлын төлөв байдал. Эх сурвалж: [34]

Үнэхээр ийм эрсдэл тохиолдвол Монгол улс оршин тогтнол, аюулгүй байдлаа хэрхэн хангах вэ? Ялангуяа эрчим хүчний аюулгүй, тогтвортой байдлаа хангах талаар үзэл баримтлал, бодлого, үйл ажиллагаанд хэр анхаарч байгаа вэ? зэрэг чухал асуудлууд тулгарч байна.

Тийнхүү дэлхий дахинд бүрэлдэж буй дэг журам, хуваагдал нь Монгол Улсын оршин тогтнол, аюулгүй байдалд шинэ сорилтыг учруулж, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаа эргэн харах шаардлага хэрэгцээ рүү аяндаа хөтлөх болсныг судлаачид төдийгүй бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид онцолж байна. Энэхүү дэвсгэр дээр Монгол Улсын эрх ашиг, аюулгүй байдлыг хангахад гео-эрчим хүчний чиглэлээр баримталж буй стратеги, үйл ажиллагааг дараах хоёр зорилтын хүрээнд хувааж болох юм. Үүнд:


1. Эрчим хүчний аюулгүй байдлыг хангах, бэхжүүлэх;
2. Эрчим хүчний тоглогчийн байр сууриа хадгалах, өргөжүүлэх.

Тус хоёр зорилтын хүрээнд Монгол Улсын урт хугацааны стратегийн баримт бичгүүд болон ойрын болон дунд хугацаанд хэрэгжүүлж буй үйл ажиллагааг тус бүрд нь авч үзье.

С. Эрчим хүчний аюулгүй байдлыг хангах, бэхжүүлэх бодлого ба сорилт

Улс орнуудын эрчим хүчний аюулгүй байдлын үзэл баримтлал хамтын ажиллагаа, харилцан хамааралт байдлаас бие даасан, үйлдвэрлэлийн болон нийлүүлэлтийн альтернатив эх үүсвэр, нөөцтэй байх стратеги рүү шилжиж буй өнөөгийн нөхцөлд Монгол Улс ч энэ талаар бодлогод анхаарах шаардлага үүсэж байна. Ялангуяа эрчим хүчийг геополитикийн зэвсгээр ашиглах, эрчим хүчний хамааралт орнууддаа шахалт үзүүлэх улс төрийн хөшүүрэг болгох стратегитай эрчим хүчний их гүрэнтэй хөршилдөг орны хувьд бусдын загвар жишээг харгалзан үзэх цаг шаардлага хэрэгцээ бий.

Ялангуяа Орос-Украины дайнаас үүдсэн эрчим хүчний хямралын улмаас улс орнуудын өрхийн эрчим хүчний зардал (нефть бүтээгдэхүүний зардлыг оруулсан дүнгээр) огцом өссөний дотор Монгол, Тажикстанд 176.1 хувь нэмэгдсэн нь бусад орнуудтай харьцуулахад толгой цохисон үзүүлэлт юм [35].



Зураг 4. 116 улс орны эрчим хүчний үнийн өсөлтийн нөлөөллийг харьцуулсан байдал. Эх сурвалж: Nature energy [35]

Монгол Улс түлш-эрчим хүчний 90 орчим хувь, төвийн болон баруун бүсийн цахилгаан эрчим хүчний систем нь нэг хөршөөсөө хамааралтай орны хувьд энэхүү эрсдэлтэй, эмзэг байдлаа шийдвэрлэх явдал нэн тэргүүний зорилт юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын гео-эдийн засгийн нэн тэргүүний зорилт бол эрчим хүчний гео-аюулгүй байдлаа хангах арга зам, хувилбарыг хөгжүүлэхэд оршино.

Энэхүү зорилгоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн сүлжээ, нефть-химийн үйлдвэр барьж байгуулах, 2030 он гэхэд цахилгаан станцуудыг өргөтгөж, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангах зорилт дэвшүүлсэн [36]. Үүний тулд Монгол улс тус салбарт олон талт хамтын ажиллагааг идэвхтэй хөгжүүлж байна. Тухайлбал, БНЭУ-ын Засгийн газрын зээлийн хөрөнгөөр жилд 1.5 сая тонн газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг 2017 онд эхэлсэн. 1.2 тэрбум долларын санхүүжилт бүхий тус үйлдвэр 2027 онд ашиглалтад орсноор Монгол улс газрын тосны бүтээгдэхүүний 55%-ийг дотооддоо хангах боломж нээгдэх юм [37]. Монголын баруун бүсийн цахилгаан эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх томоохон төсөл болох Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын УЦС-ийн санхүүжилтийн 95% болох 253.1 сая долларыг БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр шийдвэрлэж байна [38]. Жил бүр 6-7 хувиар тасралтгүй өсөж буй эрчим хүчний хэрэглээг хангах зорилгоор төвлөрсөн бус сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг хөгжүүлэхэд БНСУ-ын Засгийн газрын зээл, төвлөрсөн эрчим хүчний станцуудыг өргөтгөх, аймгуудад дулааны станц байгуулахад, олон улсын байгууллагуудын дэмжлэг, хөрөнгө оруулалт татахыг эрмэлзэж байна [39]. Гэвч 2015 онд батлагдсан “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого”-ын эхний үе шат (2012-2023)-д хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зургаан цахилгаан станцын нэг нь ч баригдаагүй, шаардлагатай хөрөнгө оруулалт 10%-д ч хүрээгүй [40]. Эгийн голын УЦС, Улаанбаатарын 5-р ДЦС, Багануурын ДЦС-ын хувьд хөрш орнуудын ил, далд шахалт, “Хил хязгааргүй гол мөрөн” зэрэг тавиул ТББ, хөлсний этгээдээр дамжуулсан тоглолтын улмаас хойшилсон гэж тооцлоо гэхэд бусад бүтээн байгуулалтын бүтэлгүйтэл Монголын шийдвэр гаргагчдын алдаа дутагдлаас үүдэлтэй.

Цаашид эрчим хүчний хангамжийн найдвартай, аюулгүй байдлыг хангахын тулд гаднын болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, технологийн дэвшлийг нэвтрүүлэхийн тулд тус салбарт үнэ тарифыг чөлөөлөх болон засаглалын реформ хийх, эрчим хүчний “халамжийн бодлого”-оосоо татгалзах шаардлага тулгарч байна. Энэхүү үйл ажиллагаа нь гадаад хүчин зүйл, нөлөөллөөс илүү дотоод бодлогоос шууд хамаарах үйл явц юм. Мэдээж улс төрийн дотоод нөхцөл, нийгмийн эсэргүүцлийг даван туулах сорилт тулгарч

байгаа ч шинэчлэл хийх шийдэмгий алхмыг одооноос эхлэхгүй бол гео-эрчим хүчний нарийн төвөгтэй нөхцөл хаяанд тулж ирээд байна.

D. Монголын эрчим хүчний тоглолтын амжилт ба алдаа


Эрчим хүч нь үйлдвэрлэл, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх болон хязгаарлах, дэд бүтэц сүлжээг өргөтгөх хийгээд таслан зогсоох, экспортод хориг тавихаас аваад импортын хамааралд оруулах, үнэ өртгийг нэмэх, бууруулах зэргээр улс орны улс төр, эдийн засгийн тогтвортой байдалд нөлөөлөх, эрчим хүчний дайн өрнүүлэх замаар геополитикийн арга хэрэгсэл болгох өргөн боломжийг өөртөө агуулдаг. Тэрчлэн эрчим хүчний нөөц, эх үүсвэр, дэд бүтэц сүлжээг эзэмших, хяналт тогтоох, ашиглах цаашлаад устгах санаархал нь дайн мөргөлдөөнийг өдөөдөг байхад нөгөө талаас хөрөнгө оруулалт хийх, улс дамнасан дэд бүтцийн сүлжээ байгуулах, технологи нэвтрүүлэх зэргээр хамтын ажиллагаа, хамсан нэгдэх зэргээр геополитикийн тоглолтын чухал хүчин зүйлсэд тооцогддог.

Хоёр дахь зорилтын хүрээнд “Алсын хараа-2050” стратегийн баримт бичигт Монгол улс 2040 онд эрчим хүчний идэвхтэй тоглогч болж, экспортын зориулалттай эх үүсвэрүүдийг нэмэгдүүлж, эрчим хүч экспортлогч орон болох, 2050 онд ногоон эрчим хүчний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлж бүс нутагтаа эрчим хүчийг тогтвортой нийлүүлэх, Зүүн хойд азийн орнуудтай хамтран азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээний санаачилгыг хэрэгжүүлэхээр тусгасан [36]. Энэхүү стратеги нь геополитикийн үүднээс улс орнуудын анхаарлыг татаж, сэрэмж болгоомжлолыг өдөөх нэгээхэн ч зүйлгүй, “эгэл даруухан амбиц”-тай зорилго юм.

Дэлхийн улс орнууд эрчим хүчний тасралтгүй өсөж буй хэрэгцээгээ хангахын зэрэгцээ нүүрстөрөгчөөс ангид ногоон эрчим хүч үйлдвэрлэх, нөөцийн хомсдолыг даван туулах ярвигтай асуудал тулгарах болов. Өөрөөр хэлбэл, 2050 он гэхэд дэлхийн хүн ам өнөөдрийнхөөс хоёр дахин их цахилгаан эрчим хүч хэрэглэхийн зэрэгцээ нүүрсхүчлийн хийг 50 хувь бууруулах, үүний тулд нүүрстөрөгчийн гаралтай эрчим хүчний үйлдвэрлэлээ багасгах зорилт дэвшүүлсэн [41]. Энэхүү нөхцөл нь цэвэр эрчим хүч, өндөр технологийн түүхий эдийн арвин нөөцтэй Монгол улс дэлхийн эрчим хүчний томоохон тоглогчидтой хамтран аюулгүй байдлаа хангах, нэг зэрэг эрчим хүчний тоглогчийн статусаа ахиулах бололцоог нээх юм.

Цаашлаад Орос-Украины дайн болон оросын эрчим хүчний геополитикийн дарамт, африкийн улс орнууд дахь улс төрийн тогтворгүй байдал гео-эрчим хүчний тавцанд эргэлт авчирсан төдийгүй эрчим хүчний шилжилтийн үйл явцыг улам түргэсгэв. Ялангуяа дэлхийн ураны болон газрын ховор элементийн өрсөлдөөнд Монгол улс аяндаа татагдан орлоо. Дэлхийн эрчим хүчний нөөцийн 10 хувийг хангаж буй цөмийн эрчим хүчний үйлдвэрлэл цаашид ч тасралтгүй өсөх

бөгөөд өмнөд хөрш л гэхэд цөмийн эрчим хүчний үйлдвэрлэлээр дэлхийд хоёрдугаарт жагсаж буй бөгөөд 2030 онд 110 АТС-тай болох, 2060 онд “Тэг нүүрс” хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх зорилт дэвшүүлээд байгаа билээ [42].



Зураг 5. Хятадын эрчим хүчний эх үүсвэрийн өсөлт сүүлийн 10 жилд. Жилийн цахилгаан эрчим хүч, тераватт цаг. Эх сурвалж: CarbonBrief, [42]

Цөмийн эрчим хүч нь Хятад, Францын хамтын ажиллагааны тэргүүлэх салбарын нэг бөгөөд энэхүү уулзвар дээр Монгол улс францын технологи, хөрөнгө оруулалтаар уран олборлон, хятадын зах зээлд нийлүүлэх нь бүх талуудын эрх ашигт нийцэж буй бөгөөд үүнээс ч өөр хувилбар бараг байхгүй юм. Франц Улс монголын уран олборлолтын салбарт 1.7 тэрбум долларын төсөл хэрэгжүүлэхээр болсон нь олон улсын талбарт үүссэн нөхцөл тохироо болон Монгол улсын хичээл зүтгэлийн үр дүн юм [43]. Цаашид монгол төдийгүй бусад улс орнууд ч хятадын эдийн засгийн бодлого, чиглэлд хөтлөгдөх шаардлага аяндаа үүсэж буй тул бид 2050-иад он хүртэл нүүрсээ тогтвортой нийлүүлж, урт хугацаандаа эрдэс түүхий эдийн бусад нөөц нийлүүлэх бэлтгэлээ өнөөдрөөс базаах хэрэгтэй гэсэн үг.

АНУ, Хятадын хооронд өрнөж буй технологийн дайн болон улс орнуудын эрчим хүчний шилжилтийн стратегиас үүдэн цэвэр эрчим хүч, өндөр технологийн түүхий эдийн (өнөөгийн байдлаар 3.1 сая нөөц тогтоогдсон) баялаг нөөцтэй орны хувьд газрын ховор элементийн геополитикийн (geopolitics of critical minerals) өрсөлдөөнд аяндаа татагдан орж буйг судлаачид тэмдэглэх болов [44]. Монгол Улс ч Герман, Өмнөд Солонгос, АНУ зэрэг гуравдагч хөршүүдтэй хамтран газрын ховор элементийн судалгаа, олборлолт, боловсруулалтын чиглэлээр идэвхтэй хамтын ажиллагаа өрнүүлж байна. Гэхдээ монголын газрын ховор элементийн гол хэрэглэгч нь өмнөд хөрш гэдгийг тооцож, өрсөлдөгч болон зөрчилтэй орнуудыг нь энэхүү салбарт татан оруулснаар монголын эрх ашигт ямар эрсдэл авчрахыг харгалзан хөдлүүштэй.

Уран болон газрын ховор элемент нь монголыг эрчим хүчний тоглогчийн жин нөлөөг шинэ түвшинд авчирна. Нөгөө талаас энэ салбарт том тоглогчдын эрх ашиг, нөлөөлөл, тохиролцооноос ангид, дан монголын сонирхол, тоглолтоор үр дүнд хүрэх ямар ч боломжгүй. Тэрчлэн гадаадын хөрөнгө оруулалт татах, технологи нэвтрүүлэхийн тулд бодлого, эрх зүйн тогтвортой бөгөөд таатай орчныг бүрдүүлэх, дэлхийн ирээдүйн чиг хандлага, өрнөл, тохироог урьдчилан тооцож, өөрийн идэвх санаачилгаа алдахгүй, эрх ашгийн уялдааг хангаж хөдлөх нь биднээс шууд шалтгаална.

Монгол Улсын эрчим хүчний тоглогчийн байр суурь, эрчим хүчний нийлүүлэлтийн сүлжээний тоглолтод чухал нөлөөтэй нэг салбар бол дэд бүтэц, тэр дундаа төмөр замын сүлжээ юм. 2010 онд Төрөөс баримтлах төмөр замын бодлогыг УИХ-аас баталж, 2013 оноос экспортын төмөр замыг барих төслийг эхлүүлсэн. Гэвч гадаад, дотоод нөлөөллийн улмаас өргөн, нарийн царигийн маргаан өрнөж гүйцэтгэлийн ажил зогссон. Оросын нөлөөний этгээд гэж олон нийтийн дунд яригддаг, тухайн үеийн Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайд, хожим ерөнхийлөгчөөр сонгогдсон Х.Баттулгын оролцоотойгоор тус төсөл олон жилийн турш бүтэлгүйтсэн. Монголын нүүрс, зэсийн тээврийн 50 хувь орчим хувийг дангаараа эзэлдэг тус маршрутын төмөр замын ажлыг өргөн царигаар хийхээр болгож, төрийн нууцад оруулан, 2020 онд эхэлж, хоёр жилийн дараа дууссан. Хэрэв 2013 ондоо баригдсан бол 375 сая тонн бүтээгдэхүүн нэмэлтээр экспортолж, хамгийн багадаа 80 их наяд төгрөгийн орлого олох байсныг холбогдох мэргэжлийн байгууллагууд тооцоолон гаргасан байдаг [45]. Цаашлаад хил дамнасан холболтын цэг тодорхойгүй, 10 жилийн өмнөхөөс даруй 1.8 дахин өндөр өртөгтэй, дамжуулан ачих байгууламжийн зардал, зарцуулах хугацаа гээд Монгол Улсад байнгын нэмэлт өртөг зардалтай тус төсөл холболтын цэгээ барьсан хойноо хятадын талтай тохирч, 2023 оноос зураг төсөл, бүтээн байгуулалтын ажил сая нэг эхэлсэн. Энэ хугацаанд Орос-Хятадын холбосон Забайкальск-Манжуурын нарийн царигийн төмөр зам 2019 онд, Нижеленинское-Тунжиан боомтын хос төмөр замын бүтээн байгуулалт 2022 онд хийгдэж дууссан. Хойд хөршийн гео-эрчим хүчний энэхүү тоглолтод Монгол Улс бүрэн хөтлөгдөж, хожлын олон боломжоо алдсан юм.

2021 онд УИХ-аас баталсан “Шинэ сэргэлтийн бодлого” хэмээх дунд хугацааны бодлогын баримт бичигт Монгол Улсын хөгжлийг хязгаарлаж буй зургаан багц асуудлын нэг нь эрчим хүч гэж тооцжээ. Эрчим хүчний бие даасан байдал, эрчим хүчний тоглогч болох зорилгыг хэрэгжүүлэх асуудал туссаны зэрэгцээ байгалийн хийн хоолойн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх агуулга туссанаараа онцлог [46]. Нийгэм-эдийн засгийн хувьд Монгол Улсад үр ашигтай байж болох хэдий ч байгаль орчин ялангуяа геополитик,

аюулгүй байдлын хувьд эрсдэлтэй үр дагавар руу хөтлөх магадлалтайг судлаачийн хувьд болгоомжилж явдгаа илэрхийлье. Үндэсний аюулгүй байдалд үзүүлэх үр нөлөөг холбогдох судалгааны институт, бодлого боловсруулагчид үнэлж дүгнэн шийдвэр гаргагчдад зөвлөж байгаа гэдэгт найдаж байна. Хийн хоолойн төсөл монголын сонирхол эрмэлзлээс үл хамааран өрнөх үйл явц хэдий ч төслийн үр нөлөөг дээшлүүлэх, хурдасгах хийгээд удаашруулах, үр ашигтай тоглолт болгох боломж бидний гарт бий.

Е. Монголын гео-эрчим хүчний тоглолтын гурван талбар

Монгол Улсын гео-эрчим хүчний бодлогод тулгарч буй асуудал, сорилт бэрхшээлийг олон улсын харилцааны ерөнхий хандлага болон Монголын гадаад бодлого, хамтын ажиллагааны стратеги, хөрш орнуудын нөлөөллийн хүрээнд тус бүр авч үзэж болно.

1) Олон улсын харилцааны ерөнхий чиг хандлага, дүр зургийн үүднээс:

Дэлхийн дэг журмын өөрчлөлт, геополитикийн тектоник шилжилт, гео-эдийн засгийн хуваагдал талцал, бүс нутаг дахь хүчний шинэ хуваарилалт зэрэг нь Монгол Улсад ихэнх төлөв эрсдэл учруулах дүр зураг харагдаж байна. Монгол Улс энэхүү адармаатай давалгаанд тэсэж үлдэх, даван туулах, оршин тогтнолоо хадгалах чиглэлээр нарийн төвөгтэй бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлага тулгарав. Улс үндэсний аюулгүй байдлаа хангахын тулд гаднын хатгаас ятгалгад автан өөр хоорондоо талцан мэтгэлцэх, эрх чөлөө, ардчиллын нэр дор популист өрсөлдөөн хийхээ хойш тавьж, бодлого стратегийн хувьд бодож тооцсоноо бодит ажил хэрэг болгоход хангалттай хугацаа үлдээгүй байх вий хэмээн эмээж байна. “VUCA ертөнц” (хувьсамтгай, тодорхойгүй, эргэлзээтэй, нарийн төвөгтэй байдал давамгайлсан орчин нөхцөлийг товчилсон илэрхийлэл)-д улс орнууд гадаад харилцаа, дипломат бодлогын хувьд тогтсон онол, зарчим, үзэл баримтлалд хайрцаглагдахгүйгээр аль болох уян хатан (resiliency), санаачилгатай байх нь үр нөлөөтэй тухай үзэл санаа бол Монголын гео-эрчим хүчний үндсэн арга барил ч байж мэднэ [47]. Энэ хүрээнд Монгол Улсын зургаа дахь Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн үеэс Монголын гадаад харилцаа илэрхий идэвхжиж, өмнөх ерөнхийлөгчийн зориудын гэмээр “унтаа байдал”-ыг богино хугацаанд нөхсөн тоглолт байлаа. Сүүлийн хоёр жилийн хугацаанд улс орнуудын төрийн тэргүүн, өндөр дээд хэмжээний зочдын Монголд хийсэн айлчлал хийгээд Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нарын АНУ, Франц, БНСУ, ХБНГУ, Япон, Их Британид хийсэн албан ёсны айлчлалын яриа хэлэлцээрийн сэдэвт эрчим хүчний хамтын ажиллагааны сэдэв байнга хөндөгдөж, зарим гэрээ хэлэлцээр амжилттай хэрэгжиж эхэлснийг Монголын талын “эрчим хүчний дипломат бодлого”-ын ололт гэж хэлж болно.

Цаашлаад дэлхийн геополитикийн эрин хоорондын шилжих завсрын үе, “бужигнаан”-ыг ашиглан шуурхай хөдөлж, эрчим хүч, дэд бүтцийн том төслүүдийг урагшлуулах, ялангуяа оросууд Украин дахь дайндаа анхаарал хандуулсан, дэлхийд эзлэх байр суурь нь суларч, улс гүрнүүдийн шахалтад автан “чих зөөлөн”-тэй болсныг нь ашиглан олон жил гацаасан Эгийн голын УЦС-ыг байгуулах, УБТЗ-ын дэд бүтцийг шинэчлэх, уран олборлох, боловсруулах ажлуудаа ахиулаад авах хэрэгтэй санагдана.

2) Гуравдагч хөршийн бодлого:

Монгол Улсын гуравдагч хөршийн бодлогын цаашдын замнал эргэлзээтэй байдалд орсон хэдий ч өнөөгийн байдлаар албан ёсоор батлагдаж хүлээн зөвшөөрөгдсөн өөр үзэл баримтлал, стратеги байхгүй. Тэрчлэн монголын “зовлон”-г ойлгодог мөнхийн хоёр хөршийн зүгээс гуравдагч хөршийн бодлогод илт дургүйцэж, хаалт хязгаар тавиагүй дээр бид хөгжингүй орнуудын хөрөнгө оруулалт, технологийг нэвтрүүлэх ажлаа идэвхтэй үргэлжлүүлэхэд буруудах зүйлгүй. Монголын гуравдагч хөршийн хамгийн том, бөгөөд анхны хөрөнгө оруулагч, “Айвэнхоу Майнз” компанийн үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн дарга Роберт Мартин Фрийдландын хэлсэнчлэн “Чингис хаанаас өвлөж авсан эрдэс баялгийн арвин нөөцтэй дэлхийн хамгийн том газар нутагтай... Монголын ард түмэн дэлхий нийтийг татахын тулд хэдэн арван жилийн нөр их хөдөлмөр, тогтвортой нөхцөлийг бүрдүүлэх нэн шаардлагатай... [48]” гэсэнтэй бүрэн санал нийлнэ. Өөрөөр хэлбэл, стратегийн салбаруудад дэлхийн томоохон тоглогчдын анхаарал, оролцоог татахын тулд бодлогын таатай бөгөөд тогтвортой орчин, хэрэгжилтийг хангахад бүхий л улс төрийн нам хүчин, улс төрчид нэгдмэл байр суурь, залгамж чанартай байх шаардлагатай гэсэн үг. Дээр дурдсан гуравдагч хөршүүдтэй эхлүүлсэн эрчим хүчний хамтын ажиллагааг энэхүү үзэл баримтлалын хүрээнд хийсэн бодит алхам гэж тооцох бүрэн үндэстэй.

3) Хоёр хөрштэй хамтран ажиллах, харилцах арга барил:

Монгол Улс эрчим хүчний хэрэглэгч хийгээд нийлүүлэгч орны хувьд хөрш гүрнүүдийн эрчим хүчний тоглолтын аян данг олох, зохицуулах, тэсэж тэвчих олон сорилтыг туулж ирсэн. Оросоос цахилгаан эрчим хүч болон нефть бүтээгдэхүүний хамааралт байдлын улмаас эдийн засгийн төдийгүй улс төрийн ил, далд дарамт шахалтад байнга автаж, “дуулгавартай дүү”-гийн дүр бүтээж ирсэн нь нууц биш. Монголын нүүрс, түүхий эдийн гол худалдан авагч Хятадтай эв зохицлыг хангах, ааш бухимдлыг хөдөлгөхгүйн хичээн “сайн дүү”-гийн дүр байдлыг үзүүлэхийг хичээж явна. Цаашид ч Монгол Улс эрчим хүчний хувьд бүрэн бие дааж, хоёр хөршөөсөө давж, давамгайлж эрчим хүчний тоглогч болох бололцоогүй. Нарийвчлан хэлбэл, оросоор түлш эрчим хүчний хувьд ор хамааралгүй болох, хятадыг алгасаж

эрдэс, түүхий эдээ бусад улсад нийлүүлэх боломжгүй тул хөршүүдтэйгээ хамтран ажиллах нь нэн тэргүүний зорилт мөн. Тийм ч учраас монголын баруун бүсийн эрчим хүчний бие даасан байдлыг хангах төслүүд, урд хөрштэй холбох дэд бүтцийн бусад бүтээн байгуулалтыг хятадын талын санхүүжилтээр амжилттай хийж ирлээ.

Цаашлаад хөршүүдээс ирж болзошгүй дарамт шахалтыг тэсвэрлэх, аргадан эвлэх, учирлан тайлбарлах замаар харилцаа, хамтын ажиллагаагаа үргэлжлүүлсээр байх болно. Монголын төр засаг нөхцөл байдалд тохируулан энэхүү асуудлыг амжилттай даван туулж буй бөгөөд өнөөгийн байдлаар УИХ-ын даргын түвшинд хойд хөршийг, Ерөнхий сайдын түвшинд урд хөршийг хариуцан ажиллаж байгаа нь ажиглагддаг. Бүхэлдээ хоёр хөршийн улс төр, эдийн засгийн хөгжлийн хандлага, албан ёсоор зарласан гадаад бодлого, хамтын ажиллагаа, аюулгүй байдлын үзэл баримтлалд дүн шинжилгээ хийж, тэдгээрт уялдуулах, угтах, баримжаалах замаар ойрын болон дунд хугацааны бодлогын төлөвлөлтдөө тусгаж явах нь Монголын эрх ашигт нийцнэ.

IV. ДҮГНЭЛТ

Сүүлийн жилүүдэд өрнөж буй олон улсын үйл явдал, чиг хандлагаас шалтгаалан геополитик, стратегийн судлагдахуун улам бүр нарийвчлагдаж, гео-улс төр, гео-эдийн засаг, геостратеги хэмээх уламжлалт ухагдахуунуудаас хэдийн хальж гео-эрчим хүч, гео-аюулгүй байдал, геотехнологи зэрэг газарзүйд суурилсан салбар дундын судалгаа идэвхтэй хөгжих болов.

Гео-эрчим хүчний үүднээс Монгол улсын гадаад бодлого, аюулгүй байдлын үзэл баримтлалд тулгарч буй сорилт бэрхшээл, гадаад, дотоод хүчин зүйл хийгээд Монгол эрчим хүчний стратегийн бодлого шийдвэр, үйл ажиллагааны бодит алхмуудад тодорхой дүн шинжилгээ хийж болно.

Дэлхийн санхүүгийн хямрал, АНУ, Хятадын худалдаа, технологийн дайн, Орос-Украины дайн, Израил-Палестины мөргөлдөөн зэрэг олон улсад үүсэж буй үйл явдлын уршгаар дэлхий дахинд гео-эдийн засгийн хуваагдалд автаж, даяаршил зогсонгсож, геополитикийн дараагийн эрин үе эхэлж байгааг судлаачид онцлох болов. 2022 онд эхэлсэн Орос-Украины дайны улмаас эрчим хүчний түүхий эдийн үнийн өсөлт, эрчим хүчний хомсдолоос шалтгаалсан хямрал нь улс орнуудад эрчим хүчний хүчний аюулгүй байдлын үзэл баримтлал, стратегиа эргэн харах, эрчим хүчний тогтолцоо, нийлүүлэлтийн сүлжээ, технологи, түүхий эдийн нөөц хувилбар, хөрөнгө оруулалтын болон зохицуулалтын бодлогоо шинэчлэх, шилжилт хийх хэрэгцээг түргэсгэв. Дэлхий дахинд бүрэлдэж буй дэг журам, сорилт бэрхшээл нь Монгол Улсыг гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, улс төр, эдийн засгийн бодлого стратеги, үйл ажиллагаагаа эргэн харах шаардлага руу хөтөлж байна. Үүний дотор

гео-эрчим хүчний бодлогын асуудал чухал бүрэлдэхүүн байх учиртай бөгөөд Монголын эрчим хүчний стратеги зорилтыг дараах хоёр чиглэлд хувааж болох юм. Үүнд:

1. Эрчим хүчний аюулгүй байдлыг хангах, бэхжүүлэх;
2. Эрчим хүчний тоглогчийн байр сууриа хадгалах, өргөжүүлэх.

A. Эрчим хүчний аюулгүй байдлыг хангах, бэхжүүлэх зорилтын хүрээнд:

Улс орнуудын эрчим хүчний аюулгүй байдлын үзэл баримтлал хамтын ажиллагаа, харилцан хамааралт байдлаас бие даасан, үйлдвэрлэлийн болон нийлүүлэлтийн альтернатив эх үүсвэр, нөөцтэй байх стратеги рүү шилжиж буй өнөөгийн нөхцөлд Монгол Улс ч энэ талаар бодлогод анхаарах шаардлага үүсэж байна. Ялангуяа Орос-Украины дайны дараагаас эрчим хүчний хямралын улмаас улс орнуудын өрхийн эрчим хүчний зардал огцом өссөний дотор Монгол Улсынх 176.1 хувь нэмэгдсэн нь бусад орнуудтай харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт аж. Монгол улс түлш-эрчим хүчний 90 орчим хувь, төвийн болон баруун бүсийн цахилгаан эрчим хүчний систем нь нэг хөршөөсөө хамааралтай орны хувьд энэхүү эрсдэлтэй, эмзэг байдлаа шийдвэрлэх явдал нэн тэргүүний зорилт юм. Өөрөөр хэлбэл, Монгол улсын гео-эдийн засгийн нэн тэргүүний зорилт бол эрчим хүчний гео-аюулгүй байдлаа хангах арга зам, хувилбарыг хөгжүүлэхэд оршино.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн гол баримт бичиг болох “Алсын хараа-2050”-д газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн сүлжээ, нефть-химийн үйлдвэр барьж байгуулах, цахилгаан станцуудыг өргөтгөж, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангах зорилт дэвшүүлсэн. Жил бүр 6-7 хувиар тасралтгүй өсөж буй Монгол улсын эрчим хүчний хэрэглээг шийдвэрлэх, бие даасан байдлыг хангахын тулд тус салбарт олон талт хамтын ажиллагааг идэвхтэй хөгжүүлж байна. Гэвч 2015 онд батлагдсан “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого”-ын эхний үе шат (2012-2023)-д бүтээн байгуулахаар төлөвлөсөн зургаан цахилгаан станцын нэг нь ч баригдаагүй, шаардлагатай хөрөнгө оруулалт 10%-д ч хүрээгүй байна. Үүнд гадна дотнын шахалт, дарамт, талцаан мэтгэлцээнээс гадна бодлогын тууштай, тогтвортой байдал дутагдсаныг хэлэх зүйтэй.

Цаашид эрчим хүчний хангамжийн найдвартай, аюулгүй байдлыг хангахын тулд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, технологийн дэвшлийг нэвтрүүлэхийн тулд тус салбарт үнэ тарифыг чөлөөлөх болон засаглалын реформ хийх, эрчим хүчний “халамжийн бодлого”-оосоо татгалзах шаардлага тулгарч байна. Энэхүү үйл ажиллагаа нь гадаад хүчин зүйл, нөлөөллөөс илүү дотоод бодлогоос шууд хамаарах үйл явц юм.

B. Эрчим хүчний тоглогчийн байр сууриа хадгалах, өргөжүүлэх зорилтын хүрээнд:

“Алсын хараа-2050” стратегийн баримт бичигт Монгол улс 2040 онд эрчим хүчний идэвхтэй тоглогч болж, экспортын зориулалттай эх үүсвэрүүдийг нэмэгдүүлж, эрчим хүч экспортлогч орон болох, 2050 онд ногоон эрчим хүчний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлж бүс нутагтаа эрчим хүчийг тогтвортой нийлүүлэх, Зүүн хойд азийн орнуудтай хамтран азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээний санаачилгыг хэрэгжүүлэхээр тусгасан. Цэвэр эрчим хүч, өндөр технологийн түүхий эдийн арвин нөөцтэй Монгол улс дэлхийн эрчим хүчний томоохон тоглогчидтой хамтран аюулгүй байдлаа хангах, нэг зэрэг эрчим хүчний тоглогчийн статусаа ахиулах бололцоог нээх юм.

Олон улсыг хамарсан эрчим хүчний шилжилт нь цэвэр эрчим хүч, өндөр технологийн түүхий эдийн арвин нөөцтэй монгол орныг эрчим хүчний геополитикийн өрсөлдөөнд аяндаа татан оруулав. Эрчим хүчний эдгээр нөөц нь монголыг эрчим хүчний тоглогчийн жин нөлөөг өсгөх хэдий ч энэ салбарт том тоглогчдын эрх ашиг, нөлөөлөл, тохиролцооноос ангид, дан монголын сонирхол, тоглолтоор үр дүнд хүрэх ямар ч боломжгүй нь тодорхой. Тэрчлэн гадаадын хөрөнгө оруулалт татах, технологи нэвтрүүлэхийн тулд бодлого, эрх зүйн тогтвортой бөгөөд таатай орчныг бүрдүүлэх, дэлхийн ирээдүйн чиг хандлага, өрнөл, тохироог урьдчилан тооцож, өөрийн идэвх санаачилгаа алдахгүй, эрх ашгийн уялдааг хангаж хөдлөх нь биднээс шууд шалтгаална.

Монгол Улсын гео-эрчим хүчний бодлогод тулгарч буй асуудал, сорилт бэрхшээлийг олон улсын харилцааны ерөнхий хандлага болон Монголын гадаад бодлого, хамтын ажиллагааны стратеги, хөрш орнуудын нөлөөллийн хүрээнд тус бүр авч үзэж болно.

Дэлхийн дэг журмын өөрчлөлт, геополитикийн тектоник шилжилт, гео-эдийн засгийн хуваагдал талцал, бүс нутаг дахь хүчний шинэ хуваарилалт зэрэг нь Монгол Улсад ихэнх төлөв эрсдэл учруулах дүр зураг харагдаж байна. Монгол Улс энэхүү адармаатай давалгаанд тэсэж үлдэх, даван туулах, оршин тогтнолоо хадгалах чиглэлээр нарийн төвөгтэй бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна. Улс үндэсний аюулгүй байдлаа хангахын тулд гаднын хатгаас ятгалгад автан өөр хоорондоо талцан мэтгэлцэх, эрх чөлөө, ардчиллын нэр дор популист өрсөлдөөн хийхээ хойш тавьж, бодлого стратегийн хувьд бодож тооцсоноо бодит ажил хэрэг болговол зохино. Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нарын АНУ, Франц, БНСУ, ХБНГУ, Япон, Их Британид хийсэн албан ёсны айлчлалын яриа хэлэлцээрийн сэдэвт эрчим хүчний сэдэв зонхилж буйг “эрчим хүчний дипломат бодлого”-ын илрэл хэлж болно.

“Монгол Улсын гуравдагч хөршийн бодлого”-ын цаашдын замнал эргэлзээтэй байдалд орсон хэдий ч

өнөөгийн байдлаар албан ёсоор батлагдаж хүлээн зөвшөөрөгдсөн өөр үзэл баримтлал, стратеги байхгүй. Хөрш орнуудаас гуравдагч хөршийн бодлогод илт дургүйцэж, хаалт хязгаар тавиагүй дээр бид хөгжингүй орнуудын хөрөнгө оруулалт, технологийг нэвтрүүлэх ажлаа идэвхтэй үргэлжлүүлэхэд буруудах зүйлгүй. Үүний тулд стратегийн салбаруудад дэлхийн томоохон тоглогчид болон гуравдагч хөршүүдийн анхаарал, оролцоог хангахын тулд бодлогын таатай бөгөөд тогтвортой орчин, хэрэгжилтийг хангахад бүхий л улс төрийн нам хүчин, улс төрчид нэгдмэл байр суурь, залгамж чанартай байх шаардлагатай байна.

Хоёр хөрштэй хамтран ажиллах, харилцах арга барилын хувьд Монгол Улс эрчим хүчний хэрэглэгч хийгээд нийлүүлэгч орны хувьд хөрш гүрнүүдийн эрчим хүчний тоглолтын аян данг олох, зохицуулах, тээж тэвчих олон сорилтыг туулж ирсэн. Оросоос цахилгаан эрчим хүч болон нефть бүтээгдэхүүний хамааралт байдлын улмаас эдийн засгийн төдийгүй улс төрийн ил, далд дарамт шахалтад байнга автаж, “дуулгавартай дүү”-гийн дүр бүтээж ирсэн нь нууц биш. Монголын нүүрс, түүхий эдийн гол худалдан авагч Хятадтай эв зохицлыг хангах, ааш бухимдлыг хөдөлгөхгүйн хичээн “сайн дүү”-гийн дүр байдлыг үзүүлэхийг хичээж явна. Цаашид ч Монгол Улс эрчим хүчний хувьд бүрэн бие дааж, хоёр хөршөөсөө давж, давамгайлж эрчим хүчний тоглогч болох бололцоогүй. Цаашлаад хөршүүдээс ирж болзошгүй дарамт шахалтыг тэсвэрлэх, аргадан эвлэх, учирлан тайлбарлах замаар харилцаа, хамтын ажиллагаагаа үргэлжлүүлсээр байх нь дамжиггүй.

ТАЛАРХАЛ

Судалгааны ажлыг хэвлүүлэхэд MCS Research Grant 202301 дугаарт грант олгон дэмжлэг үзүүлсэн MCS International ХХК-д гүн талархал илэрхийлж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. B. Shaffer, *Energy Politics*, Philadelphia, Pennsylvania: University of Pennsylvania Press, 2009.
2. S. Vanderheiden, *Politics Energy - Challenges for a Sustainable Future*, Routledge, 2011.
3. D. Yergin, *The Quest: Energy, Security, and the Remaking of the Modern World*, New York: Penguin Press, 2011.
4. John Mitchell, Peter Beck, *The new geopolitics of energy*, London: Royal Institute of International Affairs, 1996.
5. M. S. Hamilton, *Energy Policy Analysis: A Conceptual Framework*, New York: Routledge, 2013.
6. M. Klare, *Blood and Oil: The Dangers and Consequences of America's Growing Dependency on Imported Petroleum*, New York: Metropolitan Books, 2004.
7. G. Bridge, Le Billon, *Oil*, Cambridge: Polity, 2013.
8. З.Безинский, *Выбор. Мировое господство или глобальное лидерство.*, Москва: Международные отношения, 2010.
9. G. Chufirin, *Economic Co-operation and Collective Security in Asia.*, New Delhi: Vikas Publishing House, 1976.
10. B. Gokay, "Oil, war and geopolitics from Kosovo to Afghanistan," *Journal of Southern Europe & the Balkans*, vol. 4, no. 1, pp. 5-13, 04 8 2010.

11. Chandra, "Geopolitics of Central Asian Energy Resources & Indian Interest," *Journal of Peace Studies* Vol. 16, vol. 16, no. 1-2, pp. 86-95, 1-6 2009.
12. S. Mityakov, Heiwai Tang, K. Tsui, "Geopolitics, Global Patterns of Oil Trade, and China's Oil Security Quest," HKIMR Working Paper, vol. 32/2011, 26 10 2011.
13. R. Heinberg, "Resource Wars: Geopolitics in a World of Dwindling Energy Supplies," 20 6 2011. [Online]. Available: <https://oilprice.com/Geopolitics/International/Resource-Wars-Geopolitics-In-A-World-Of-Dwindling-Energy-Supplies.html>.
14. C. Arvanitopoulos, "Thesis: Geopolitics of Oil in Central Asia," *A Journal of Foreign Policy Issues*, 2002.
15. P. Bustelo, "CHINA AND THE GEOPOLITICS OF OIL IN THE ASIAN PACIFIC REGION," Real Instituto Elcano, Vols. Working paper, 38/2005, 2005.
16. L. Patey, "Iran & the New Geopolitics of Oil: An Annotated Bibliography.," DIIS (Danish Institute for International Studies), vol. Working paper 2006: 24, 2006.
17. Gupta A., Arora S., "Control Oil - Rule the World!," *University of Petroleum & Energy Studies*, p. 16, 2013.
18. F. Gere, *New Geopolitics*, Kastalia editions, 2007.
19. C. Pascual, *the new geopolitics of energy*, Columbia: Center on Global energy policy, 2015.
20. Cos, kun B. B., Carlson R., "New Energy Geopolitics: Why Does Turkey Matter?," *Insight Turkey*, vol. 12, no. 3/2010, pp. 205-220, 2010.
21. D.U. Aribogan, M. Bilgin, "New Energy Order Politics Neopolitics: From Geopolitics to Energieopolitics," *Uluslararası İlişkiler*, vol. 5, no. 20, pp. 109-132, 2009.
22. Barry D. Solomon, Kirby E. Calvert, *Handbook on the Geographies of Energy*, Cheltenham: Edward Elgar, 2017, p. 579.
23. Mane-Estrada, "European energy security: Towards the creation of the Geoenergy space," *Energy Policy*, vol. 34, no. 18, pp. 3773-3786, 2006.
24. I. Vidakis, G. Baltos, "Security Aspects of "Geoenergeia" and the Significance of Energy Resources Management in International Politics," *Munich Personal RePEc Archive*, p. 3, 2015.
25. Vidakis, Ioannis and Baltos, Georgios and Balodis, Janis, "Geopolitics of Energy versus Geoenergy," *Munich Personal RePEc Archive*, p. 20, 2017.
26. F. Moreira, "Energy as Social, Strategic and Geopolitical Equation," in *Geopolitics of Energy and Energy Security*, IDN, 2017, pp. 41-48.
27. H. J. Mackinder, "The Geographical Pivot of History," *The Geographical Journal*, pp. 198-321, 2004.
28. Shekhar Aiyar, Anna Ilyina, "Charting Globalization's Turn to Slowbalization After Global Financial Crisis," 8 02 2023. [Online]. Available: <https://www.imf.org/en/Blogs/Articles/2023/02/08/charting-globalizations-turn-to-slowbalization-after-global-financial-crisis#:~:text=The%20%E2%80%9CSlowbalization%E2%80%9D%20that%20followed%20the,trade%20amid%20rising%20geopolitical%20tensions..>
29. IMF, "Economic Fragmentation and the Future of Multilateralism," 2023.
30. D. Zorigt, "Scenarios for a 'new normal' in geopolitics," 21 07 2023. [Online]. Available: <https://www.gisreportsonline.com/r/geopolitics-new-normal/>.
31. Chris Bradley, Jeongmin Seong, "On the cusp of a new era?," 20 10 2022. [Online]. Available:

- <https://www.mckinsey.com/capabilities/risk-and-resilience/our-insights/on-the-cusp-of-a-new-era#/>.
32. Pascual, C., "The Geopolitics of Energy: From Security to Survival," Brookings, pp. 1-16, 08 01 2008.
 33. Alexis Crow, Samir Saran, "The Geopolitics of Energy Transition: A Guide for Policymakers, Executives, and Investors," 2021.
 34. Rodolfo Campos, Julia Estefania Flores, "Geopolitical fragmentation and trade," 31 07 2023. [Online]. Available: <https://cepr.org/voxeu/columns/geopolitical-fragmentation-and-trade>.
 35. Yuru Guan, Jin Yan, "Burden of the global energy price crisis on households," Nature energy, vol. 8, pp. 304-316, 03 2023.
 36. МУЗГ, "“Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого," УБ, 2020.
 37. Densmaa, "Газрын тос боловсруулах үйлдвэрийг 2027 ашиглалтад оруулах үүрэг болголоо," 13 9 2023. [Online]. Available: <https://www.barilga.mn/n/23854/>.
 38. Ш.Батболд, "Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төслийн Тусгайлсан зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурна," 11 10 2023. [Online]. Available: <https://montsame.mn/mn/read/328824>.
 39. МУИХТГ, "“Эрчим хүчний хангамжийн найдвартай байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар” ирүүлсэн асуулгад хариуллаа," 28 04 2023. [Online]. Available: <https://www.parliament.mn/n/30005/>.
 40. Р.Номин, "Эрчим хүчний салбар сэргэхгүй бол шинэ сэргэлтийг горьдолтгүй...," 07 10 2023. [Online]. Available: <http://time.mn/tsM.html?fbclid=IwAR2B2ilk6iSm66lmhNeZWfQaa0y-yrtaOvc6oB7jkau-FCM9ZRhkG6CfDW8>.
 41. Б. Ариунзаяа, "Ураны ирээдүй ба эрчим хүчний шинэ хэрэглээ," 19 05 2023. [Online]. Available: <https://montsame.mn/mn/read/319480>.
 42. Patel, "Q&A: How China is using nuclear power to reduce its carbon emissions," 14 08 2023. [Online]. Available: <https://www.carbonbrief.org/qa-how-china-is-using-nuclear-power-to-reduce-its-carbon-emissions/>.
 43. M. Pene-Lassus, "Mongolia opens way for uranium mining with \$1.7bn French deal," 13 10 2023. [Online]. Available: <https://asia.nikkei.com/Business/Materials/Mongolia-opens-way-for-uranium-mining-with-1.7bn-French-deal>.
 44. M. Y. Zhang, "Mongolia's Rare Earths Diplomacy and Its Geopolitical Implications," 12 08 2023. [Online]. Available: <https://thediplomat.com/2023/08/mongolias-rare-earths-diplomacy-and-its-geopolitical-implications/>.
 45. Ш. Батболд, "Гашуунсухайт боомтын төмөр замын шилжүүлэн ачих терминалын бүтээн байгуулалт эхэллээ," 06 05 2022. [Online]. Available: <https://montsame.mn/mn/read/297766>.
 46. МУИХ, "Шинэ сэргэлтийн бодлого," 2021. [Online]. Available: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390082551211&showType=1>.
 47. K. S. Rana, "The VUCA world and diplomacy," 23 10 2017. [Online]. Available: <https://www.diplomacy.edu/blog/vuca-world-and-diplomacy/>.
 48. Р. Фрийдланд, "“Монголын Уул уурхайн 7 хоног” чуулганд “Айвэнхоу Майнз” компанийн үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн дарга Роберт Фрийдландын тавьсан илтгэл," 14 10 2023. [Online]. Available: <https://ikon.mn/n/2zdd>.
 49. Н.Эрхбаяр, "Зөвч-Овоо УРАНЫ орд монголчуудын "АМАНД ОРОХ ШАР ТОС"," 17 10 2023. [Online]. Available: https://ikon.mn/opinion/2z4a?fbclid=IwAR3OHdBO7-mM1213i8ink8wFPk-UuMOV87Fti7rjUxq5fESjcAesLCC_H5s.

ЗОХИОГЧИД



Дашзэвгийн Мягмарсүрэн

Доктор (Ph.D), Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Хүний нөөцийн албаны дарга. 2002, 2006 онд Монгол Улсын Их Сургуулийн Нийгмийн ухааны факультетийг Улс төр судлаач мэргэжлээр бакалавр, магистрын зэрэгтэй төгссөн. 2014 онд Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуульд улс төрийн ухаанаар доктор зэрэг хамгаалсан. Бүс нутаг судлал, эрчим хүчний геополитик, бодлогын шинжилгээний чиглэлээр судалгаа явуулдаг.